


# Бодлогын шинжилгээний матрицыг ашиглан МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар (Ховд аймгийн Булган сум)


Гончигсумлаагийн ГАНЗОРИГ<sup>1</sup>, фон Крамон-Таубаделийн ШТЕФАН<sup>2</sup>

<sup>1</sup>Герман улсын Гёттингений Их Сургуулийн Докторант

<sup>2</sup>Герман улсын Гёттингений Их Сургуулийн ХАА-н Эдийн Засаг, Хөдөөгийн Хөгжил тэнхимийн Доктор, Профессор



www.watercope.org



## Оршил, зорилго

Монгол улс нь байгалийн нөөцөөр баян улс юм, жишээ нь малчин өрх (МӨ)-үүдэд үнэгүй ашиглагддаг бэлчээр гэх мэт. 45 сая мал нь бэлчээрийн даацыг хэтрүүлэхэд хүргэж байна. Судалгааны зорилго нь:

- Судалгааны нутагт МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг тогтоох;
- МАА-н бүтээгдэхүүн үйлвэрлэлийн Хувийн болон нийгмийн ашгийн зөрүүг багасгах бодлогыг санал болгох.



Зураг 1. Дээд нарийний зуслан, судалгааны айл ямаа саах үед

## Үр Дүн

Бусад малыг бодвол хамгийн их мөнгөн орлого оруулдаг учраас ямааны тоо толгойгоо нэмэгдүүлэхийг малчид зорьж байна. Гэвч, ямааны бэлчээрлэх онцлогоос шалтгаалан бэлчээр ихээр доройтож байна.

- Малчин айлын жилийн нийт орлогын ихэнхийг буюу 54.3%-ийг ямааны ноолуур бий болгож байна;
- Мөнгөн орлогыг бий болгогч хоёрдогч худалдаа нь амьд малын худалдаа байна;
- Нэг өрх МАА-н бүтээгдэхүүн зарж жилд дунджаар 2.48 сая төгрөг (2.02 мянган доллар) олж байна.
- Нүүдлийн МАА нь олон үйл ажиллагааг хамарсан ээдрээтэй аж ахуй тул гол бүтээгдэхүүнийг судлах.

## Хүснэгт 1. Нэг өрхийн жилийн дундаж үйлдвэрлэл, 2011 он

№	Бүтээгдэхүүн	Ямаа	Хонь	Үхэр	Адуу	Тэмээ	Нийт
1	Малын тоо (Толгой)	71	18	10	5	2	104
2	Мах(КГ)	194.9	68.8	160.8	25.2	13.2	462.9
3	Сүү (Литр)	583.6	20.9	1,857.3	36.7	3.6	2,502.0
4	Арьс, шир (Ширхэг)	14	4	1	0	0	19
5	Ноолуур (КГ)	22.5					22.5
6	Ноос (КГ)		24.3			6.7	31.0
7	Үхрийн хялгас (КГ)			0.0			0.0
8	Дэл, сүүл (КГ)				2.5		2.5
9	Цагаан идээ (КГ)		302.8*		33.8	0.8	337.4

\* Үнээ, ямаа, хонины сүүгээр хийсэн цагаан идээ

## Хүснэгт 2. Нэг өрхийн жилийн дундаж мөнгөн орлого, 2011 онд

Бүтээгдэхүүн	Дундаж (000 ТӨГ)	СТХ (000 ТӨГ)	Х.Бага (000 ТӨГ)	Х.Их (000 ТӨГ)	Тус бүтээгдэхүүн-нийг худалдсан өрхийн тоо
Ноолуур	1,345.8	1213.8	0	9425.0	194
Амьд мал худалдах	551.6	944.9	0	6865.0	104
Мах	196.9	1041.3	0	10675.2	19
Арьс, шир	188.6	181.2	0	2125.9	196
Сүү	57.5	211.5	0	2262.5	42
Тэмээний ноос	29.1	81.6	0	750.0	77
Хонины ноос	20.3	132.0	0	1725.0	25
Адууны дэл, сүүл	2.9	23.9	0	325.0	17
Цагаан идээ	87.9	233.9	0	1830.5	60
<b>Нийт</b>	<b>2,480.6</b>	<b>4,064.1</b>	<b>0</b>	<b>35,984.1</b>	<b>197</b>

## Арга Зүй

Бид Монке, Пийрсоны (1989) Бодлогын Шинжилгээний Матрицыг ашиглав. Энэ нь бүтээгдэхүүний ашгийг хувийн ба нийгмийн үнээр тооцдог. Тоо мэдээ нь 197 малчин өрхийн санал асуулгаас гарсан задаргаатай тоо мэдээ юм.

	Орлого	Зардал		Ашиг
		Худалдаалагд-даг орц (ХО)	Дотоод орц (ДО)	
Хувийн үнэ	Хувийн орлого (A)	ХО-н Хувийн зардал (B)	ДО-н Хувийн зардал (C)	Хувийн Ашиг (D=A-B-C)
Нийгмийн үнэ	Нийгмийн орлого (E)	ХО-н Нийгмийн зардал (F)	ДО-н Нийгмийн зардал (G)	Нийгмийн Ашиг (H=E-F-G)
Зөрүү	I=A-E	J=B-F	K=C-G	L=D-H=I-J-K

## Хүснэгт 3. Бодлогын Шинжилгээний Матриц(Монке, Пийрсон, 1989)

Худалдаалагдах орц нь гадаадаас авдаг, эсвэл гадагшаа зарагддаг орц, харин дотоод орц нь гадаадаас авдаггүй, гадагшаа зарагддаггүй орц юм.

## Дүгнэлт

Хэдийгээр ноолуур нь хамгийн их мөнгөн орлого бий болгодог ч нийгмийн хувьд ашиггүй байх боломжтой учир нь ямаа бэлчээрийг доройтуулдаг.

